

Мэдээллийн тэнцвэрт байдлын онолын асуудалд*

Б. Болд-Эрдэнэ*

* МУИС, НУФ, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, дэд доктор, дэд профессор

Ардчилал, зах зээлийн эдийн засаг хэмээх үг ойлголт бидний амьдралын "тэмдэг нэр" тодотгол болоод арав гаруй жил болжээ. Түүний байнгын дагуул үнэнч анд нь "чөлөөт хэвлэл" юм. Гэвч өнөөдөр улс төрийн тогтолцоонд нэг намын ноёрхол оршиж, эдийн засгийн орчин хямрал зөрчлөөр ээрэгдэж, үндэсний телевиз радио төр засгийн мэдэлд хэвээр байна. Хичнээн олон эрдэмтэн судлаач, гадаадын мэргэжилтэн, улс төрч, нийгмийн зүтгэлтэн ардчилал, зах зээл, чөлөөт хэвлэлийн тухай ярьж бичив?! Үр дүн хомс чамлалтай л байна. Магадгүй бид их дээрээс, ерөнхий, тогтолцооны төвшинд асуудлыг ойлгож ирсэн байж болох юм. Тэгээд ч хэн ч харсан боломжийн өнгө зүс, хэлбэр төрхтэй харагдаад байдаг мөртлөө ахуй хэрэглээний ая даахгүй "Эрээний бараа" шиг нийгэм улс төрийн тогтолцоог бий болгосон байж болох юм. Үүний томоохон нотолгоо нь чөлөөт хэвлэлийн асуудал

мөн. Хууль эрх зүйн орчныг тодорхой хэмжээнд бүрдүүлж, төр засгийн шууд хяналт дарангуйллын тогтолцоог үгүй болгож, иргэний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө бодитой болсон гэх зэргээр чөлөөт сэтгүүл зүйн үндсэн зарчим, төлөв нэгэнт бий болсон ч мэдээллийн эх сурвалжийн асуудал орхигдож, мэдээлэл авах эрх чөлөө далд, зохион байгуулалттай сүлжээнд замарч, нөлөө бүхий мэдээллийн хэрэгслүүд шууд болон шууд бусаар төр засагт үйлчлэх болов. Тиймээс чөлөөт хэвлэлийн зүй ёсны бодит байдал үгүйлэгдсээр байна. Энэхүү үгүйллийн нэгэн нэхэл бол мэдээллийн тэнцвэрт байдал мөн.

2001 онд НҮБ Хөгжлийн хөтөлбөрийн газрын тэтгэлгээр МХХ-д хийсэн "Өдөр тутмын сонины нийгэм улс төрийн сэдэвт мэдээний эх сурвалж"-ийн судалгаагаар мэдээллийн тэнцвэрт байдал огт үгүй нь харагджээ. Үүнд "Өдрийн сонин"-ы мэдээний эх сурвалж 100 хувь, "Өнөөдөр" сониных 83 хувь, "Зууны мэдээ" 100 хувь, "Монголын мэдээ"-ийнх 98,1 хувь нь тус тус мэдээллийн нэг эх сурвалжийг үндэслэн мэдээ нийтэлж байжээ. Гэхдээ энэ бол

* Энэ өгүүллийг ARC-ийн дэмжлэгээр хийсэн "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санаа бодол" судалгааны хүрээнд бичсэн болно.

мэдээллийн эх сурвалж нь тодорхой мэдээний хүрээнд буй үзүүлэлт юм. Мэдээллийн эх сурвалжийн тодорхойгүй байдал "Өдрийн сонин"-д 70 хувь, "Өнөөдөр"-т 84 хувь, "Зууны мэдээ"-д 84 хувь, "Монголын мэдээ" 68 хувийн үзүүлэлттэй гарчээ. Өөрөөр хэлбэл мэдээллийн эх сурвалжийн тэнцвэрт байдал бүү хэл тодорхой байдал үгүй байна гэсэн үг. Тиймээс ч хэвлэл мэдээллийн нэр төр, байр суурь илт унаж, худал, бодит бус гүтгэлэг төөрөгдүүлэлтийн хэрэглүүр мэтээр үнэлэгдэх болов. Энэ бол чөлөөт хэвлэлийн жинхэнэ үнэ цэнэ, үр нөлөө цаашилбал нийгмийн амьдрал хөгжилд муу үр дагавартай юм. 2002 оны 6-р сард Азийн судалгааны төвөөс санхүүжүүл-

сэн МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн судалгаагаар олон нийтийн 56,4 хувь нь хэвлэл мэдээллийн агуулгын чанарын асуудалд шүүмжлэлтэй, сөрөг ханддагаа илэрхийлжээ. Бодит бус, тэнцвэргүй, дуулиан шуугиант, гүтгэлэг, ёс зүйд үл нийцэх мэдээлэл бол өнөөгийн сэтгүүл зүйн "муу мэдээ" сүүдэр нь болоод байна. Тэгээд ч энэ судалгаагаар нийт оролцогчдын 85,6 хувь нь хэвлэл мэдээлэл нийгэм улс төрийн амьдралд бүрэн нөлөөлж чадахгүй байна гэж үзжээ. Энэ бол тун чухал асуудал мөн. Өнөөдөр монголын нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засгийн тогтолцоо бүхэлдээ нэг улс төрийн намын хяналт нөлөө дор байна. Ийм цаг үед оюун

санаа, мэдээллийн харилцааны үр нөлөө юу юунаас чухал билээ. Өөрөөр хэлбэл төр засгийн бодлого үйл ажиллагааны хүрээнд нийгэм, хувь хүний эрх ашиг сонирхлыг илэрхийлдэг, түүгээрээ тулгамдсан бэрхшээлт асуудлыг гаргаж тавьдаг, энэ нь хяналт засаглалыг бүрдүүлэх уг сурвалж болдог мөн чанар манай хэвлэл мэдээлэлд үгүйлэгдэж байна.

Мэдээллийн бодит нөлөө нь чөлөөт хэвлэлийн үнэт зүйл мөн. Нийгэм улс төрийн амьдралд нөлөөлөх явдал нь бидний

«
**Мэдээллийн тэнцвэрт байдал нь
нийгмийн мэдээллийн харилцаа
эрүүл саруул байж, нийгмийн бүлэг,
давхарга, хүчний эрх ашиг
сонирхлыг бүрэн дүүрэн илэрхийлнэ
гэсэн үг юм.**

»

эрхэм зорилго болох чөлөөт байхуйн утга учир юм. Үр нөлөө үгүй мэдээллийн тогтолцоонд чөлөөт хараат орчны ач холбогдол, ялгаа үгүй билээ. Тиймээс бид тэрхүү бодит үр нөлөөний

талаар бодох, эргэцүүлэх хэрэгтэй болжээ. Энэ бодол эргэцүүллийн нэг нь ч мэдээллийн тэнцвэрт байдал болой. Мэдээллийн тэнцвэрт байдал нь нийгмийн мэдээллийн харилцаа эрүүл саруул байж, нийгмийн бүлэг, давхарга, хүчний эрх ашиг сонирхлыг бүрэн дүүрэн илэрхийлнэ гэсэн үг юм. Мөн нийгмийн амьдралын асуудал, үйл явдал, үзэгдлийн учир шалтгаан, үнэн мөнийг нээж, хэвлэл мэдээлэл чөлөөт байхын утга учир, нийгмийн оюун санаа, сэтгэл зүйд бодитой байр суурь эзэлнэ гэсэн үг юм. Харин өнөөдөр энэхүү чөлөөт хэвлэлийн утга учир, зорилго бидэнд үгүй байна.

Нийгэм гэгч хүнээс эхэлж, хүнээр төгсдөг амьд организм мөн. Тэгээд ч социологийн шинжлэх ухааны эцэг Огюст Конт "Нийгмийг үхэлгүй оршин байдаг хувь хүн шигээр авч үзэх ёстой" гэсэн байдаг. Нийгэм судлал ч үндсэн агуулгаараа хүний сэтгэл зүйг яг хуулан давтдаг, тэгэхдээ зүйрлэшгүй өргөнөөр, түвэгтэйгээр давтдаг. Өөрөөр хэлбэл нийгэм нь том мөнхийн бас хувьсан өөрчлөгддөг хүн юм. Энэ бүхнийг нуршихын учир нь нийгмийн эрүүл саруул зүй ёсны мэдээллийн орчин бүр тодруулбал тэнцвэрт байдал нь хүнээр бол амьдрах цаг үедээ бодит дүн шинжилгээ хийж чаддаг, тулгамдсан бэрхшээл саадыг давах оюуны чадвартай, урагш тэмүүлэгч эрмэлзлэл, эр зоригтой нийгмийн зайлшгүй эрэлт хэрэгцээ болохыг тэмдэглэх гэсэн юм. Зөвхөн нэг урсгалыг нь л хараад машин замаар гардаг тэнэг хүн байвал юу болох вэ? Өнөөдөр биш юмаа гэхэд маргааш аюул осолд орно биз дээ. Түүн шиг зөвхөн нэг үзэл бодлоор, эсвэл нэг хэсэг хүний "цонхоор" хардаг нийгэмд хямрал сүйрэл ойрхон биз ээ.

Нийгэмд зөрчил, тулгамдсан асуудал зайлшгүй юм. Учир нь тэр амьд ертөнц. Тиймээс зөрчлийг зүгшрүүлж, асуудлыг шийдвэрлэх ёстой. Ерөөс зөрчил бол нийгмийн хөгжил хөдөлгөөний эх үндэс, дэвшлийн утга учир юм. Зөрчилгүй нийгэм бол эсвэл үхэж буй эсвэл бүр сөнөсөн ертөнц юм. Хүн зөрчил бэрхшээлийг давж, ойлгож, ухамсарлаж, сургамж авч төлөвшдөг. Нийгэм ч тийнхүү хөгждөг. Харин ямар зөрчил байна, түүний шалтгаан юу болох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлнэ гэдэг бол хөгжлийн

хүчин зүйл юм. Нийгэмд тэнцвэртэй мэдээллийн харилцаа байхын ач холбогдол ч зөрчлийг мэдэх, ойлгох, шийдвэрлэхэд оршино. Гэхдээ эдгээрээс хэвлэл мэдээллийн гол ачаа үүрэг нь зөрчлийг тодорхойлох, асуудлыг нээхэд оршино. Олон нийтийн мэдээллийн харилцааны мөн чанарыг ч асуудлыг шийдвэрлэх бус харин түүнийг нээж, нийгэмд гаргаж тавихад оршино гэдэг. Нөгөө талаар энэхүү мөн чанарын гүнд нийгмийн янз бүрийн эрх ашиг сонирхлыг илэрхийлэгч бүлэг давхаргын үзэл санаа байр суурийн үнэ цэнэ оршиж байгаа юм. Монголчууд "Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй" хэмээн хэлцдэг. Энэ ч бас мэдээллийн тэнцвэрт байдлын утга учир. Бүр цаашилбал хэвлэл мэдээллийн туйлын зорилго бол ямар нэг үнэн шийдэл дүгнэлт гэсэн хийсвэр харьцангуй асуудалд бус харин асуулт гаргахад орших, үүнийхээ тулд аль болох нийгмийн өргөн хүрээг хамарсан дуу хоолой байх хэмээж болно. Тиймээс мэдээллийн тэнцвэрт байдал бол бидний зорилго, зайлшгүй даган мөрдөх бурхан юмуу эсвэл эзэн хааны сургаал номлол алин ч биш харин үйл ажиллагааны мөрдлөг байх нь ээ. Дээр өгүүлсэн мэдээллийн засаглалын мөн чанар ч "асуулт тавьдаг" байгаа юм. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээлэл хууль тогтоодоггүй, хуулийг хэрэгжүүлдэггүй, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй харин хууль амьдралд нийцэж байна уу, гажуудаж байна уу, яагаад хэрэгжихгүй байна гэж асуулт гаргадаг засаглал юм. Энэ бол мэдээллийн нийгэмд үзүүлж буй бодит нөлөө юм. Түүнчлэн асуулт хүчтэй, боди-

той байхад тэнцвэрт мэдээллийн ач холбогдол, ашиг тус болно. Цэлмэг тэнгэрт аянга ниргэх шиг асуулт тавина гэдэг бол мэдээллийн засаглал, түүний бодит мөн чанар мөн.

Одоо асуудлыг өөр нэг өнцгөөс харъя. Мэдээллийн тэнцвэрт байдал гэдэг үгэн дээр эргэцүүлье. Мэдээлэл гэдэг үгийн үндэс нь мэд. Энэ нь мэдэх, мэдрэх, мэдээ орох, мэдээлэх гээд үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл мэд хэмээх үгийн язгуурт буй үйлдлийн үнэ цэнэ, бодит байдал, үнэн, шинийг олоход байна. Тиймээс ч мэдээллийн үнэ цэнэ бодит үнэнд байгаа юм. Тэгж ч үздэг.

Бодит байдал ба мэдээлэл хооронд бидний оюун санаа сэтгэл зүрх оршиж, төлөвшиж байдаг.

Тэгвэл бодит байдал гэж юу вэ? Бас л харьцангуй ойлголт. Бодит байдал гэдэг бол нэг талаас тусгаж буй

субъектийн, нөгөө талаас тусгагдаж буй объектийн үй түмэн хүчин зүйлийн уялдаа холбоо, учир зүй дээр оршин байдаг ойлголт. Тиймээс жинхэнэ, төгс бодит байдал гэгч үл нээгдэм үнэн болно. Түүнд хүрэхээс ойртох нь илүү чухал. Өөрөөр хэлбэл нэг асуудал, зөрчлийн бодит үнэнийг ойлгоно гэдэг ч боломжгүй зүйл бөгөөд харин түүнд хэр ойр дөхөж вэ гэдэг бидний боломж. Гэхдээ тэрхүү боломж маань олон талаас нягтлах, шинжих, эх сурвалжласнаар сая нээгдэнэ. Мэдээл-

лийн үнэ цэнийн хэмжүүр төвшин ч эх сурвалжийн тэнцвэр, эрх ашиг сонирхлын олон талт хүрээ, учир шалтгааныг янз бүрийн хүчин зүйл гэх зэрэг нягтлал шинжлэлд байна. Долоо хэмжиж нэг огтол гэдэг ч мэдээллийн "эсгүүрт" чухал үг юм. Дээр өгүүлсэн Азийн судалгааны төвөөс санхүүжүүлсэн 2002 оны судалгаанд оролцогчдын 11 хувь нь өнөөгийн хэвлэл мэдээллийн дутагдлыг "эх сурвалжаа нягталдаггүй" гэсэн нь ч тохиолдлын дүн биш билээ. Мөн 16,7 хувь нь "мэдээллийн тэнцвэрт бус байдал" бол манай мэдээллийн "чанарын" гол дутагдал хэмээжээ.

Өөрөөр хэлбэл мэдээллийн эх сурвалжаа нягтлах магадлах асуудал бодит амьдралд хэрэгжихгүй байна гэсэн үг.

Харин тэнцвэр бол ертөнцийн оршихуйн хууль. Цэцэг навчны гадаад хэлбэр ч тэгш хэмийн хуулинд захи-

«
**Харин тэнцвэр бол ертөнцийн
оршихуйн хууль. Цэцэг навчны
гадаад хэлбэр ч тэгш хэмийн
хуулинд захирагддаг. Амьтдын
амьдрал ертөнц ч гадаад
орчинтойгоо зохицох, аюул
гамшгаас сэргийлж амьд байхад
орших аж. Амьд байна гэдэг
тэмцэлдэнэ гэсэн үг**
»

рагддаг. Амьтдын амьдрал ертөнц ч гадаад орчинтойгоо зохицох, аюул гамшгаас сэргийлж амьд байхад орших аж. Амьд байна гэдэг тэмцэлдэнэ гэсэн үг. Ертөнц байгалийн бүх юмс үзэгдэл өөр хоорондоо уялдаа холбоотой. Хүний нийгэм ч мөн адил дунд бүлгийн нөлөө байр суурь, хүчтэй үед тогтвортой хөгжиж байдаг гэдэг. Энэ бол нийгмийн бүлгүүдийн тэнцвэржилт юм. Бас улс төрийн засаглалын хуваарилалт ч төрийн эрх мэдлийн тэнцвэрийг бий болгоход оршдог.

Бурхны шашны үйл үр хэмээх ойлголт ч ертөнцийн уялдаа холбоо, сэтгэл санааны амар амгалан тэнцвэрийг номлодог. Өөрөөр хэлбэл тэнцвэрийн хуулинд захирагддаг. Тэнцвэр алдагдвал сүйрэл мөхөл болно. Тиймээс мэдээллийн тэнцвэрт байдал бол өөрөө мэдээлэл байх, тийнхүү үнэлэгдэхийн уг сурвалж юм. Нөгөө талаар мэдээллийн хууль бол тэнцвэрт байдал болох нь. Мэдээллийн мөн чанарыг ч сонголтыг хялбаршуулах гэдэг. Сонголт бол тэнцвэрийг олох гэсэн тэнцвэрт нөхцөл орчны үйл зорилгоос өөр юу ч биш. Тэгэхээр сонголт бол угаасаа тэнцвэрийн төлөөх тэмцэл болно. Энэ бүхэн мэдээлэл тэнцвэртэй байх нь зүгээр нэг үйл ажиллагааны мөрдлөг зарчим бус харин мэдээллийн зайлшгүй чанар, үнэ цэнэтэй байхуйн асуудал болох нь харагдаж байна. Тэгэхээр мэдээллийн тэнцвэрт байдлыг хангах бус харин мэдээлэл тэнцвэртэй байх ёстой ажээ.

Гэхдээ бидний ойлгож буй тэнцвэрт мэдээлэл ч бодит байдлаас хол, түүнд ойртох нь гол зорилго нь байдаг тийм нэг агуулга гэдгийг дахин тэмдэглэе. Энэ бол бодит байдалд хэр дөхөж ойртсон бэ гэдгээр л мэдээллийн үнэ цэнэ хувьсан өөрчлөгдөж байдаг төдийгүй ерөөс мэдээлэл мөн эсэхийг тодорхойлох ёстой болно гэсэн хэрэг юм. Эндээс мэдээллийн бодит байдал үнэн гэсэн тусдаа бие даасан ойлголт байдгийг хялбар харж болно. Яагаад гэвэл үг яриа, бичиг үсэг, дүр дүрс гэсэн бидний харилцаа мэдээллийн тэмдэг хэрэглүүрийн чадвар боломж бодит байдлыг төгс бүрэн дүүрэн хүргэхэд учир дутагдалтайн дээр бидний

оюун санаа ч мэдээллийг боловсруулах, хүртэх, ойлгохдоо янз бүр, ялгаатай басхүү хязгаартай юм. Энэ утгаараа ч мэдээллийн тэнцвэрт байдал нь сэтгүүлчийн ур чадвар, мэргэжлийн түвшний үзүүлэлт болно. Тэр бүү хэл мэдээллийн бодит үнэн бол сэтгүүл зүйн сайн сайхны зорилго үлгэр жишээ хэдий ч амьдралд үл биелэх үзэл номлол ч гэх нь бий. Үүнийг ч сэтгүүлчийн баримтын сонголт, боловсруулалт нь өөртөө субъектив бүр тэс ондоо ойлголт утга санаа агуулга илэрхийлэх нөхцөл шалтгааны хүчин зүйл болдог гэж тайлбарладаг. Тиймээс ч мэдээллийн төөрөгдүүлэлт, гуйвуулга, ухуулга нь баримтын сонголтоор л бий болдог гэдэг. Мөн мэдээллийн хэлбэр, цаг хугацаа, орон зайн хязгаарлалт ч бодит бус агуулгын шалтгаан болох нь бий. Гэвч энэ бүхэн мэдээллийн тэнцвэрт байдал оргүй хоосон зүйл гэсэн үг биш ээ. Харин сэтгүүлчийн ур чадвар мэдлэг боловсрол мэргэшлийн ёс зүйн асуудал өндөр түвшинд байж мэдээллийн тэнцвэрт байдал бий болдог, тэр нь үр нөлөө, үнэ цэнийг нь тодорхойлдог гэсэн үг юм. Тэгээд ч Америкт 1920-иод онд дуулиан шуугиан, улс төрийн туйлшралд нэр хүнд нь унасан сонин хэвлэлийнхэн шинэ үзэл номлолыг дэвшүүлж байсан түүх бий. Үүнд:

*Баримтыг үзэл бодлоос ялган зааглах
Сэтгэлийн хөөрөл догдлол үгүй
агуулгыг дээдлэх*

Олон нийтэд өргөн хүрээний мэдээлэл ойлголт өгөх зорилгоор янз бүрийг эх сурвалж, нийгмийн эрх ашиг сонирхлыг тусгахыг онцолжээ. Гэвч цаг хугацааны шалгуураар хамгийн бодитой үзэл

Баримтлал нь мэдээллийн тэнцвэрт байдал болохыг тогтоосон ажээ. Баримт ба үзэл бодол хоорондын харьцаа нь нэлээд харьцангуй юм. Баримт үзэл бодлыг агуулж, үзэл бодол нь баримтыг тодорхойлж болдог учир тэдгээрийн тэнцвэрт харьцааг тогтоох нь нэлээд түвэгтэй болно. Нийгмийн үйл явдал, амьдралын өөрчлөлт хөдөлгөөнөөр мэдээллийн сонголт, нийлүүлэлт, чиглэл үйл явц өрнөж байдаг нь ч тийнхүү үзэл бодол баримтын харьцааг хадгалахад хүндрэл бэрхшээлийг учруулж байдаг. Энд үйл ажиллагааны гэхээсээ үнэлэмжийн харьцааны тухай онцолж байна. Сэтгэл зүйн догдлол, хөөрлийн асуудал ч мөн адил харьцангуйн онолоор тодорхойлогдоно.

Цэвэр "агуулга" хэмээх ойлголт ч үгүй мэт санагдана. Алив агуулгыг ойлгогч, ухамсарлагч хүний дотор ертөнц гээч тэр чигээрээ сэтгэл зүй, догдлол, мэдрэмж төдийгүй аливаа олон нийт, нийгмийн амьдрал, үйл явдал, үзэгдэл өөрөө сэтгэл зүйн төлөв байдлын үр дагавар байдаг оршино. Тэгээд ч улс төр, нийгмийн зөрчил зөрөлдөөн, байр суурийн ялгаа, хувьсал өөрчлөлтийн цаг үеийг түүхийг тэмдэглэгч сэтгүүл зүй догдлол мэдрэмжээс хол байх нь боломжгүй зүйл юм. Тэр бүү хэл ертөнц бол "хүсэл зориг төсөөлөл юм" гэсэн Шопенгаурын үзлээр бол догдлол мэдрэмжгүй нийгэм түүний үйл амьдрал,

үзэгдэл гэж хоосон цэцэрхэл болой. Ингээд бидэнд ердөө мэдээллийн эх сурвалж түүний цаана буй нийгмийн бүлэг давхарга, эрх ашгийн сонирхлын тэнцвэрээс өөр юм үлдсэнгүй. Ерөөс хүний оюун санааны логик үнэн ч энэ юм. Нөгөө талаар мэдээллийн эрх чөлөөний уг сурвалж зайлшгүйг оюун санааны эрүүл саруул, бие даасан байдал гэдэг. Хүн сайн муу, сайхан муухай, зөв бурууг ойлгох үнэлэх чадвартай гээд энэ бол сэтгүүл зүйн утгаараа өөрийнхөөрөө ойлгох эрх чөлөөг уншигч, сонсогч, үзэгчдээ өгч буй хэрэг билээ.

«
Баримт ба үзэл бодол хоорондын харьцаа нь нэлээд харьцангуй юм. Баримт үзэл бодлыг агуулж, үзэл бодол нь баримтыг тодорхойлж болдог учир тэдгээрийн тэнцвэрт харьцааг тогтоох нь нэлээд түвэгтэй болно.
»

Мэдээллийн эх сурвалжийн тэнцвэрт байдал гэдэг ч нэлээд нарийн түвэгтэй арга, үйл ажиллагаа юм. Үүнд зерчилт, эрс тэс байр суурь ашиг сонирхлыг илэрхийлж буй талуудын эрх тэгш илэрхий-

лэл, түүнчлэн уг үйл явдал, асуудлыг бүрэн тодорхойлж чадахуйц мэдлэг боловсрол, мэдээлэлтэй мэргэжилтний болоод түүний үр дагавар нөлөөг хүртэгч нийгмийн, мөн зохицуулалт, бодлого чиглэлийг тодорхойлогч төр засгийн, зарим тохиолдолд уг асуудалд зорилготойгоор эрх ашиг, сонирхолтойгоор оролцож буй талын гээд олон байр суурь, үзэл бодлыг нэгтгэх хэрэгтэй болно. Мөн баримт, гэрчийн ишлэл, нотолгоо болох бичиг, дүрс бичлэг гээд мэдээллийн "түүхий эд"-ийн мэргэжлийн боловсруулалт

чухал юм. Энэ бүхэн бол гарцаагүй ур чадварын асуудал мөн. Энэхүү дүгнэлтийн өөр нэг нотолгоо нь ч мэдээллийн бодит байдлын хүрээний шинэчлэлт, шинэ сэтгүүл зүйн урсгалууд юм. Үүнд **"шинэ сэтгүүл зүй"** хэмээх утга зохиолын агуулга хандлага болох өгүүлэмж, харилцамж, эргэцүүлэмж, дүр зэргээр бодит байдлыг тодорхойлогч сэтгэхүйн оролцоо, ач холбогдлыг чухалчилсан мэдээллийг боловсруулах арга барил, **итгэн үнэмшүүллийн сэтгүүл зүйн** шууд илт тодорхой нэг байр суурь, үйл явдлыг баримтлагч хандлага, **Эрэн сурвалжлах сэтгүүл зүй** хэмээх сөргөлдөгч байр суурийн үндсэн дээр далд нууц баримт мэдээллийг бүхий л арга хэрэгслээр нээдэг, арга барил **судалгааны сэтгүүл зүй** хэмээх нийгмийн далд тодорхойгүй асуудлыг шинжлэх уааны арга зүйд үндэслэн нээж, мэдээллийн задлал дүн шинжилгээ хийдэг хандлага, **иргэний сэтгүүл зүй** хэмээх нийгэм улс төрийн мэдээлэлд иргэдийн идэвхтэй оролцоог бий болгох, улмаар нийгмийн эрх ашиг, сонирхлыг өөрсдөөр нь тодорхойлуулах, шүүмжлэл өрнүүлэх зэрэг зорилго онцлогийг номлодог урсгал эдгээрийг жишээлж болно. Энэ бүх шинэчлэлт нь сэтгүүл зүйн уламжлалт мэдээллийн бодит байдлыг өөрчлөх зорилгод үйлчилж байв. Өөрөөр хэлбэл илүү өнгө, баримт, мэдрэмж, дуу чимээг сэтгүүл зүйд бий болгох зорилготой байлаа. Мөн мэдээллийн бодит байдлыг ямар олон талаас харж тодорхойлж, бас үйл ажил болгож болохын нотолгоо мөн. Гэвч эцсийн дүндээ сонгодог мэдээллийн бодит

байдал буюу эх сурвалжийн тэнцвэр нь хамгийн боломжит төгс арга барил болох нь харагдсан юм. Тиймээс мэдээллийн тэнцвэрт байдал бол юуны өмнө бодит тодорхой эх сурвалжаас авсан үзэл бодол болон баримтаас эхэлнэ.

Харин төгсгөл нь нийгмийн янз бүрийг эрх ашиг сонирхлын адил, ижил харьцаа ажээ. Үүнийг өөрөөр нэг зүйлийн хоёр тал ч гэж ойлгож болно. Эцсийн дүгнэлт нь чөлөөт хэвлэл бол мэдээллийн тэнцвэрт байдал, тэр дундаа мэдээлэл авах эрх чөлөө гэсэн томьёололд хүргэж байна. Гэхдээ үзэл бодол байр суурийн тэнцвэрт харьцаа, агуулга хэлбэрийн нэгдэл, асуудлыг нээгч зорилго энэ бүхэн мэдээлэл авах эрх чөлөөний утга учир, үнэнд агуулагдаж буйг хэлэх хэрэгтэй. Мөн мэдээллийн тэнцвэрт байдлыг төгс төгөлдөр хадгална гэдэг ч харьцангуй асуудал билээ. Ерөөс ертөнцөд төгс бүрэн зүйл тэр дундаа оюун санаа сэтгэл зүйн ертөнцөд үгүй билээ. Энэхүү хууль ч бидэнд хамаатай. Хамаатай учир ч мэдээллийг эрж хайх, нээлттэй түгээх эрх чөлөө чухал болно. Энэ нь мэдээллийн чөлөөтэй орчин үгүйгээр мэдээллийн тэнцвэрт байдал хоосон үзэл номлол болно гэсэн үг. Мэдээллийн тэнцвэрт байдал бол бодит үнэнд хүрэх зөв зам мөн. Тиймээс мэдээллийн тэнцвэрт байдлыг хангая гэдэг бол чөлөөт мэдээллийн орчинг бий болгоё, зөв замаа олъё гэсэн хэрэг. Гэвч энэ бол бодит байдалд амьдралын ердийн нэгэн хэм хэмжээ, эрэлт шаардлага л юм.

1. Зулькафиль М., Чойсамба Ч. 2001. Чөлөөт хэвлэл өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
2. Сигел С. 2003. Хөөрсөн түмэн ба гэмт хэрэг (Орч. Б.Даш-Ёндон). Софи.
3. Шопенхауер А. 1997. Светът как воля и представа. София.
4. Поппер К. 2001. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. УБ.
5. Мерилл Дж., Деннис Э. 1997. Беседы о масс медиа. М.
6. Merill J., Jack Odell S. 1983. Philosophy and journalism. N.-Y.

Some Theoretical Problems of Information Balans

In this article, author analized the balance which is the base of reality of information. Also he sum up the information – balance of today's Mongolian newspapers which is based on the research statictics, financed by ARC.

Author considered information balance is defined relationship between fact and source. On the other hand, the value of free press is the information balance.